



ӨМНӨХ ҮГ

Монгол Улсын Шинжлэх ухааны академийн Хими, химийн технологийн хүрээлэнгээс эрхлэн гаргадаг “Эрдэм шинжилгээний бүтээл” (Bulletin of Institute of Chemistry and Chemical Technology, BICCT) сэтгүүлийн 2022 оны шинэ дугаар болох 10 дахь дугаарыг та бүхэнд хүргэж, сэтгүүл маань *EBSCO discovery service* системд индекслэгдсэн шинэ мэдээг дуулгаж байгаадаа таатай байна.

Энэхүү дугаар нь Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг “Алсын хараа-2050”, дунд хугацааны зорилтод хөтөлбөр “Шинэ сэргэлтийн бодлого”-д туссан зорилтыг хэрэгжүүлэх, Монгол Улсад химийн шинжлэх ухаан, химийн аж үйлдвэрийг хөгжүүлэх, улс орны өмнө тулгарч буй асуудлыг шийдвэрлэхэд химичдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор зохион байгуулагдсан “ХИМИ-2022” үндэсний анхдугаар эрдэм шинжилгээний хуралд ирүүлсэн нийт 40 эрдэм шинжилгээний өгүүллээс шалгарсан 21 өгүүллийг тусгай дугаар болгон DOI дугаартайгаар хэвлэж байгаагаараа онцлог юм. Эдгээр өгүүллүүд нь органик хими, органик бус хими, нүүрсний хими технологи, экологийн хими, байгалийн нэгдлийн хими, материал судлал, биохими, хүнсний хими зэрэг химийн үндсэн салбараас гадна химийн боловсрол, физик гэх мэт бусад салбарт хийгдсэн шинэлэг үр дүнгээр бичигдсэн нь бас нэг онцлог болж байна.

Органик бус химичид зэсийн техноген баяжмалыг сульфатжуулан шатааж, зэс ялган авах оновчтой нөхцөлүүдийг тогтоосон бол У.Баясгалан нарын судлаачид фотохимийн салбарт фенилпропионы хүчлийн уламжлал болох транс-4-трифлуорометил фенилпропионы хүчлийн фотодеминерализацийн урвалын судалгааны сонирхолтой үр дүнг гарган авчээ.

Монгол орны баруун бүсийн халуун рашааны гидрогеохимийн судалгаагаар халуун рашааны газрын гүний усан сангийн температурыг 98-134°C байгааг илрүүлж, бинарын системийг ашиглан цахилгаан эрчим хүч гарган авах боломжтойг тогтоосон байна.

Б.Минжмаа нар зэс болон цайраар баяжуулсан дрожжийн гидролизат хүний үсний нягтаршил, диаметр, нэгж уутанцарт байх үсний тоо ширхэг, морфологид хэрхэн нөлөөлж буй судалгааг явуулжээ.

Химийн боловсролын салбарт хийгдсэн судалгаагаар ерөнхий боловсролын сургуулийн химийн багш нарын оролцох, шинжлэн судлах, тайлбарлах, нарийвчлах, үнэлэх гэсэн үе шатуудтай 5E сургалтын загвар бүхий хичээл төлөвлөлтийг рубрик арга ашиглан үнэлгээ хийсний дүнд төлөвлөх чадвар дутмаг, харин оролцох, шинжлэн судлах шатуудыг төлөвлөж чадаж байгааг илрүүлэв.

Манай сэтгүүлийн энэхүү дугаарт хөндлөнгийн шүүмжлэгчээр хамтран ажилласан шүүмжлэгч нартаа талархал илэрхийлэхийн сацуу өөрсдийн судалгааны ажлын шинэ үр дүн, шинэлэг санаагаа нэгтгэн өгүүллээ ирүүлсэн эрхэм эрдэмтэн судлаачид та бүхнийхээ эрдэм судлалын ажилд өндөр амжилт хүсье.

Улс орны хөгжлийн түлхүүр болсон Монгол улсын шинжлэх ухаан хөгжин цэцэглэх болтугай.

ЕРӨНХИЙ РЕДАКТОР

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР ЛХАСҮРЭНГИЙН ЖАРГАЛСАЙХАН